

МХЕГ-ЫН ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ
ЛАБОРАТОРИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Б.МАР



БАТЛАВ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
..... Б.НАРАНТУЯА



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2017 оны ... сарын ... өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

2017 07 21 14

Нэг талаас Мэргэлийн Хяналтын Ерөнхий Газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лаборатори (цаашид лаборатори гэх) нөгөө талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид хөгжлийн төв гэх) нар дараах нөхцлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг 2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр байгуулав.

Нэг. Зорилго

1.1 Энэхүү гэрээний гол зорилго нь эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний улсын бүртгэлийн дээж болон тандалт судалгаа, хяналт үнэлгээний дээжинд шинжилгээ ийж, чанар, аюулгүй байдлыг үнэлэхэд талуудын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Нийтлэг үндэслэл

2.1 Талууд үйл ажиллагаандаа “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хууль, “Стандартчилал тохирлын үнэлгээний тухай” хууль, “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторид тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC17025”, “Эмийн чанарын хяналтын лабораторид тавих ерөнхий шаардлага MNS6621:2016” стандарт, Эрүүл мэнд спортын сайдын 2015 оны Журам батлах тухай 13-р тушаал, МХЕГ-ын даргын 2016 оны А/167 тоот тушаалын 4-р хавсралт “Эм биобэлдмэлийн лабораторийн шинжилгээнд хүлээн авах дээжийн тоо хэмжээ” тушаал болон энэхүү гэрээ болон холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллана.

Гурав. Талуудын хүлээх эрх, үүрэг

3.1 Хөгжлийн төвийн эрх, үүрэг

3.1.1 Дээжийг шинжилгээнд шаардлагатай тоо хэмжээгээр, шинжилгээний хүсэлтийн хамт (бүртгүүлэгч байгууллагаар дамжуулан) хүлээлгэн өгч, хариуг авах;

3.1.2 Шинжилгээг холбогдох зармакопей, стандарт баримт бичгийн дагуу үзүүлэлт тус бүрээр хийлгэх, тогтоосон хугацаанд гаргуулан авах эрхтэй.

Хуудсыг баталгаажуулсан

Лабораторийн төлөөлж:

Хөгжлийн төвийг төлөөлж:

3.1.3 Тандалт судалгааны шинжилгээнд шаардлагатай баримт бичиг, материал хэрэгслийг гарган өгөх;

3.1.4 Эмийн улсын бүртгэлийн дээжийг эцсийн бүтээгдэхүүний бүтээгдэхүүний шинжилгээний сертификат, шинжилгээний аргачлал болон аргын баталгаажуулалтын тайланг цаасаар болон электроноор ирүүлэх ба хуулбарласан баримт бичигт хуулбар үнэн гэсэн тэмдгийг дарсан байх;

3.1.5 Холбогдох дүрэм, журам, орсон өөрчлөлтийн талаар лабораторийг цаг тухайд нь мэдээллээр хангах;

3.1.6 Эмийн бүртгэлийн материалын шинжилгээний арга, аргачлалд нэмэлт өөрчлөлт орсон тухай бүр аргачлалыг лабораторид хүргүүлэх үүрэгтэй.

3.2 Лабораторийн эрх, үүрэг

3.2.1 Дээжийг шинжилгээний хүсэлт, холбогдох баримт бичгийн хамт хүлээн авах;

3.2.2 Шинжилгээнд шаардлагай баримт бичиг, материал хэрэгсэл, зарим урвалж, стандарт бодисыг гаргуулан авах;

3.2.3 Дээжийн савлалтын бүрэн бүтэн байдал алдагдсан тохиолдолд дээжийг хүлээн авахгүй байх ба энэ талаар шинжилгээний хүсэлтийн хуудсанд тодорхой дурдан буцаах эрхтэй.

3.2.4 Шинжилгээг холбогдох баримт бичигт заасан аргачлалын дагуу үзүүлэлт бүрээр бүрэн гүйцэтгэж, үнэн бодит шинжилгээний үр дүнг гарган өгөх;

3.2.5 Шинжилгээний дүнг гарсан өдөрт утсаар эсвэл цахим хэлбэрээр мэдээлэх;

3.2.6 Шинжилгээ хийх хугацаанд бүртгэлийн баримт бичгийн бүрэн бүтэн байдал, хадгалалтыг бүрэн хариуцах;

3.2.7 Тухайн жилд шинжилгээнд хамрагдсан дээжийн талаар тайланг жилийн эцэст, бусад мэдээ, судалгааг шаардлагатай тохиолдолд тухай бүрд хөгжлийн төвд хүргүүлэх үүрэгтэй.

Дөрөв. Шинжилгээний төлбөр тооцооны талаар

4.1 Лаборатори нь шинжилгээний төлбөрийг шинжлэх үзүүлэлт тус бүрээр хүсэлт гаргагчаас нэхэмжилнэ.

4.2 Эмийн улсын бүртгэлийн дээжийн шинжилгээний төлбөрийг эм бүртгүүлэгч байгууллага бүрэн хариуцан төлнө.

4.3 Тандалт судалгаа, яналт үнэлгээний дээжийн шинжилгээний төлбөрийг хөгжлийн төв эсвэл тухайн судалгааг санхүүжүүлэгч байгууллага хариуцан төлнө.

Тав. Талуудын хүлээх хариуцлага

5.1 Талууд шинжилгээний явц, үр дүнгийн нууцлал, шинжилгээний үнэн зөв, найдвартай байдлыг бүрэн хариуцна.

Лабораторийн төлөөлж:

Хуудсыг баталгаажуулсан

Хөгжлийн төвийг төлөөлж:

5.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Гэрээг баталгаажуулах, дүгнэх

6.1 Гэрээ нь 2 талын төлөөлөл гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Гэрээний биелэлт болон шинжилгээний гүйцэтгэлийг тухайн жилээр нь үнэлж, дүгнэнэ.


6.3 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол харилцан тохиролцож болно.

6.4 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд нэг жилийн хугацаанд адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан:

Лабораторийг төлөөлж:

ХАБҮЛЛ-ийн Эмийн хяналтын
лабораторийн менежер

 Д.ӨЛЗИИДУЛАМ

Утас: 62-263 267

Гар утас: 96660810

мэйл: lab@inspection.gov.mn

d_ulziidulam@yahoo.com

Хөгжлийн төвийг төлөөлж:

ЭМХТ-ийн Эм, эмнэлгийн
хэрэгслийн албаны дарга

..... Г.ЦЭЦЭНСАНАА

Утас: 11-310-304

Гар утас: 99072126

мэйл: tsetsensanaa@hdc.gov.mn

Лабораторийн төлөөлж:

Хуудсыг баталгаажуулсан

Хөгжлийн төвийг төлөөлж:



